МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 12 өдөр Дугаар А/157 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, 4.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, аудитын албанаас хамтран зохион байгуулсан "Манлайлагч санхүүгийн алба" аяны болзлыг ханган сумдын санхүүгийн албыг хошуучлан манлайлж ажилласан Тариалан сумын санхүүгийн албыг "2021 оны Манлайлагч Санхүүгийн алба"-аар шалгаруулж, болзлын дагуу 500,000 (Таван зуун мянга) төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

2. Аяны хүрээнд нэгдүгээр байр эзэлсэн Тариалан сумын санхүүгийн албаны ажилтнуудыг сарын үндсэн цалингийн 30 хувиар, хоёрдугаар байр эзэлсэн Цэцэрлэг сумын санхүүгийн албаны ажилтнуудыг үндсэн цалингийн 25 хувиар, гуравдугаар байр эзэлсэн Цагаан-уул сумын санхүүгийн албаны ажилтуудыг сарын үндсэн цалингийн 20 хувиар, дөрөвдүгээр байр эзэлсэн Төмөрбулаг сумын санхүүгийн албаны ажилтнуудыг сарын үндсэн цалингийн 15 хувиар, тавдугаар байр эзэлсэн Бүрэнтогтох сумын санхүүгийн албаны ажилтнуудыг сарын үндсэн цалингийн 10 хувиар тус тус нэг удаа шагнаж урамшуулахыг Төсвийн шууд захирагч нарт зөвшөөрсүгэй.

3. Аяны хүрээнд сүүлийн байруудад орсон Цагаан-Үүр, Эрдэнэбулган, Ренчинлхүмбэ, Жаргалант, Ханх сумдын Засаг дарга нарт төсөв санхүүгийн талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахад анхаарч, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах талаар төлөвлөгөө гарган, улирал бүр хэрэгжилтийг тооцон ирүүлж, хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

4. Урамшууллын 500,000 (Таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН